



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№165 /378/

2022.09.16

Цаг үе, үйл явдал

ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙГ ЗАЛРУУЛЖ МЭДЭГДЭЛ ХИЙВ



Цахим орчинд 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Батлан хамгаалах яам, Оросын Холбооны Улсын Батлан хамгаалах яамны логог ашиглан "Сайн дурын цэрэг татлага" нэрийн дор ОХУ-ын Луганск, Донецкийн бүгд найрамдах улсад явуулж байгаа цэргийн тусгай ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын иргэн 18-45 насны цэргийн насны эрчүүдийг гэрээт цэргийн албанд бүртгэж эхэллээ" хэмээх хуурамч мэдээг түгээсэн байна.

Энэхүү хуурамч мэдээллийг няцааж 9 дүгээр сарын 16-ны өдрийн 11.00 цагт Офицеруудын ордны "Соёмбо" танхимд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар хэвлэл мэдээллийн ажилтнуудад мэдээлэл өглөө.

Тэрбээр "Энэ мэдээлэл нь худал. Бид ОХУ-ын Элчин сайдын яамны цэргийн атташе руу холбогдож тодруулахад ор үндэсгүй мэдээлэл гэдгийг хэлсэн. Уг мэдээлэл нь

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, хоёр орны дипломат харилцаанд сэв суулгах ноцтой мэдээлэл. Сүүлийн үед Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд сөргөөр нөлөөлөх мэдээллийг санаатайгаар болон санамсаргүй байдлаар олон нийтэд түгээж байгаа нь маш ноцтой асуудал юм.

Иймд иргэдэд үнэн бодит

мэдээллийг хүргэх үүднээс энэхүү мэдээллийг хийж байна. Энэхүү мэдээлэл нь санаатайгаар нийтэлсэн мэдээлэл бөгөөд бид тагнуул, хууль хяналтын байгууллагуудад хандаж уг мэдээллийн эзэн, холбогдогчийг тогтоох болно. Цаашид иргэдийн зүгээс ийм хэлбэрийн мэдээллийн үнэн бодит байдлыг бодитой эх сурвалжаас нь авч байх хэрэгтэй" гэж мэдэгдсэн юм.

ХУРАНДАА Б.ОТГОНБАЯР

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА, "СОЁМБО" РЕДАКЦЫН ӨВӨЛ СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛТЭЙ ТАНИЛЦЛАА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг 9 дүгээр сарын 15-ны өдөр ЦДБЭЧ, "Соёмбо" редакцын үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэлжилтийг хэрхэн хангасан талаарх нөхцөл байдалтай танилцлаа.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дарга хурандаа Г.Золзаяа, "Соёмбо" редакцын дарга, ерөнхий редактор хурандаа С.Төмөрхуяг нар байгууллагынхаа үйл ажиллагааны талаар танилцуулж цаашдын хөгжлийн чиг хандлага болон тулгамдаж буй асуудлын талаар илтгэл тавьсан юм.

Ажлын хэсгийнхэн ЦДБЭЧ, "Соёмбо" редакцын бүтэц зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаж, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, Засгийн газрын хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, өвөлжилтийн бэлтгэлийг хэрхэн хангасан байдалд үнэлэлт дүгнэлт өглөө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 15	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 21

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.400	3.410
EUR 🇪🇺	3.385	3.420
CNY 🇨🇳	482	488
RUB 🇷🇺	53	54
JPY 🇯🇵	24.10	24.40
KRW 🇰🇷	2.44	2.47

ЗУРХАЙ

2022.09.16 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 21

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ
САРЫН
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАР
БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.30-19.04

Барилдлага:

Шид

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Хол газар яваар одогсод зүүн урд зүгт мөрөө гаргавал зохистой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 616,220,249

Эдгэрсэн

Нийт: 595,369,450

Нас барсан

Нийт: 6,526,105

ТА БҮХЭНДЭЭ БАЯРЛАЛАА



Иргэн-цэргийн харилцаа хамтын ажиллагааны хүрээнд "Sound of Mongolia" ХХК-аас БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд 8 нэр төрлийн соёл

гэгээрлийн техник хэрэгслийг сэлбэгийн хамт хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн жагсаалын талбайд боллоо.

Уг ажиллагаанд "Sound of Mongolia" ХХК-ий орлогч дарга Д.Зундуй, мотобуудлагын батальоны штабын дарга дэд хурандаа Г.Хатанбаатар

болон цэргийн багийн бие бүрэлдэхүүн оролцлоо.

Энэхүү техник хэрэгсэл нь цэргийн багийн бие бүрэлдэхүүний соёл хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын ажлыг зохион байгуулахад чухал шаардлагатай юм.

Мотобуудлагын батальоны

удирдлага "Sound of Mongolia" ХХК-ий хамт олонд талархсанаа илэрхийлэн дурсгалын зүйл гардуулж СТА ахлагч Г.Мөнхбат ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

ЦЭРГИЙН БАГИЙН ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ АХЛАХ ДЭСЛЭГЧ Л.ТҮМЭНДЭЛГЭР

“АЛДАР”-ЫНХАН БАГИЙН ДҮНГЭЭР ТЭРГҮҮЛЛЭЭ



Монголын бүх ард түмний XV их наадмын буудлага спортын төрөл 2022 оны 9 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" ТӨҮГ-ын тирэнд зохион байгуулагдлаа.

Тэмцээнд 19 аймаг, 9 дүүргийн 110 гаруй тамирчин өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны Л.Ундралбат дасгалжуулагчтай баг тамирчид 4 алт, 5 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж, багийн

дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Тэмцээний 10 метрийн хийн гар бууны эрэгтэйчүүдийн дасгалд ОУХМ Э.Даваахүү мөнгө, 10 метрийн хийн гар бууны эмэгтэйчүүдийн дасгалд СМ Э.Хишигдэлгэр хүрэл, 10 метрийн хийн урт бууны эрэгтэйчүүдийн дасгалд ОУХМ Н.Баяраа хүрэл, 10 метрийн хийн урт бууны эмэгтэйчүүдийн дасгалд ОУХМ О.Янжинлхам хүрэл, 10 метрийн хийн

гар бууны холимог багийн төрөлд ОУХМ Э.Даваахүү, Г.Хэрлэнцэцэг нар мөнгө, 10 метрийн урт бууны холимог багийн төрөлд ОУХМ Н.Баяраа, О.Янжинлхам нар алт, 25 метрийн олимпын хурдан буудлагын холимог багийн төрөлд ОУХМ Э.Даваахүү, Г.Хэрлэнцэцэг нар алт, 50 метрийн 3 байдлаас буудах эрэгтэйчүүдийн төрөлд ОУХМ Н.Баяраа мөнгө, 50 метрийн

3 байдлаас буудах эмэгтэйчүүдийн төрөлд ОУХМ О.Янжинлхам мөнгө, 25 метрийн спорт гар бууны төрөлд ОУХМ Г.Хэрлэнцэцэг хүрэл, гар бууны хурдан буудлагын төрөлд ОУХМ Э.Даваахүү алт, гавьяат дасгалжуулагч Л.Ундралбат мөнгө, 50 метрийн урт бууны холимог багийн төрөлд ОУХМ Н.Баяраа, О.Янжинлхам нар алтан медаль тус тус хүртлээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)